

“ЭКО-АЗИ” ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэ дүрэм нь “Эко-Ази” Байгаль орчин, менежментийн дээд сургуулийн оюутны зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, зарчим, бүтэц зохион байгуулалт, тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа, эрх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж зохицуулахад оршино.
- 1.2 “Эко-Ази” байгаль орчин, менежментийн дээд сургуулийн оюутны байгууллагыг сургуулийн “Оюутны зөвлөл” /цаашид оюутны зөвлөл гэх/ гэж нэрлэнэ.
- 1.3 Оюутны зөвлөл нь тус тус сургуульд суралцаж буй оюутнуудыг нэгтгэсэн олон нийтийн байгууллага мөн.
- 1.4 Оюутны зөвлөл нь Монгол Улсын Үндсэн хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль, тогтоомж бусад акт болон сургуулийн дүрэм, дотоод журам, оюутны зөвлөлийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

Хоёр. Оюутны зөвлөлийн үндсэн зорилго

- 2.1 Оюутны зөвлөл нь оюутны нийтлэг эрх ашгийг хамгаалах, тэдний хүсэл эрмэлзлэлийг илэрхийлэн, нийт оюутнуудыг төлөөлөх
- 2.2 Оюутны зөвлөл нь оюутныг сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэх төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэн, суралцах бүтээлч идэвхийг өрнүүлэх
- 2.3 Багш, оюутны бүтээлч эвсэг хамт олныг бүрдүүлэх, сургуулиа хөгжүүлэх үйлсэд оюутны идэвхитэй оролцоог нэмэгдүүлэх
- 2.4 Нийт оюутнуудын дунд зохиогдох соёл хүмүүжлийн ажилд оюутнуудаа хамруулан оролцуулах

Гурав. Оюутны зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн зарчим

- 3.1 Оюутны зөвлөл нь үйл ажиллагаандаа ардчилсан зарчмыг удирдлага болгон, оюутнуудын нас, бие, сэтгэхүйн онцлогийг харгалзан ажиллана.
- 3.2 Оюутан хоорондын харилцан мэдээлэл, санал солилцох бүх талын бололцоог бүрдүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулна.
- 3.3 Оюутан, сургуулийн удирдлагыг хооронд нь холбож, оюутны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажиллана.
- 3.4 Оюутны зөвлөл нь Монгол Улсын Үндсэн хууль, МОН-ны дүрэм, сургуулийн дотоод журам болон бусад холбогдох хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.
- 3.5 Монголын Оюутны Холбооны албан ёсны гишүүн байж үйл ажиллагаанд идэвхитэй оролцоно.

Дөрөв. Бүтэц, зохион байгуулалт

- 4.1 Оюутны зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.
- 4.2 Оюутны зөвлөлийн даргыг нийт оюутны хурлаас сонгоно.

Оюутны зөвлөлийн даргын эрх үүрэг, хариуцлага

4.3 Оюутны зөвлөлийн дарга нь зөвлөлийн хуралдааныг даргалах, гаргасан шийдвэрийг үндэслэн холбогдох хүмүүст үүрэг өгөх, биелүүлэхийг шаардах эрхтэй.

4.4 Оюутны зөвлөлийн дарга нь удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллана.

4.5 Оюутны зөвлөлийн дарга нь оюутантай холбоотой асуудлаар холбогдох албан тушаалтан, багш оюутнуудад зохих шаардлага тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.

4.6 Оюутны зөвлөлийн дарга нь өөрийн хийх ажлын төсөв, төлөвлөгөөг сургуулийн захиргаа, болон холбогдох албан тушаалтнаар батлуулж биелэлтийн талаар улиралд нэгээс доошгүй удаа нийт оюутнууд болон “Оюутны зөвлөл”-д тайлагнах үүрэгтэй.

4.7 Оюутны зөвлөлийн дарга нь зөвлөлийн гаргасан шийдвэрийг нийт оюутанд мэдээлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэгтэй.

Тав. Оюутны зөвлөлийн гишүүний эрх, үүрэг

Гишүүн нь дараах эрх, үүрэгтэй:

5.1 Оюутны зөвлөлийн удирдлага, үйл ажиллагааны талаар мэдээлэл авах,

5.2 Оюутны зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх /шударгаар шүүмжлэх, шагналд урамшилд тодорхойлогдох/

5.3 Оюутны зөвлөлөөс зохион байгуулж буй үйл ажиллагаанд идэвхитэй оролцох

5.4 Мэдлэг боловсролоо байнга дээшлүүлэх

5.5 Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай биелүүлэх

5.6 Сурлага, хүмүүжлээрээ үлгэр жишээч, шударга, хүмүүнлэг байх

Зургаа. Санхүүжилт

Оюутны зөвлөлийн санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэж болно.

6.1 Сургуулийн төсвөөс /шаардлагатай үед санхүүжилт гаргана/

6.2 Гадаад дотоодын байгууллага болон хувь хүмүүсийн хандив, тусламж

6.3 Гишүүдийн татвар

6.4 Өөрийн үйл ажиллагаанаас олох орлого

6.5 Оюутны зөвлөлийн данс нь “Эко-Ази” БОДС-ийн салбар данс байна.

6.6 Оюутны зөвлөлийн тэргүүн, сургуулийн захирал болон сургалтын албатай зөвшилцсөний үндсэн дээр данснаас зарцуулалт хийнэ.

Долоо. Бусад зүйл

7.1 Оюутны зөвлөлийн үйл ажиллагаа, санхүүгийн зарцуулалт нь сургуулийн удирдлага, санхүүгийн алба болон нийт гишүүдийн өмнө нээлттэй байна.

7.2 Оюутны зөвлөл нь гадаад, дотоодын их, дээд сургууль болон тэдгээрийн оюутны байгууллага, бусад олон нийтийн байгууллагуудтай харилцаа холбоо тогтоон ажиллана.

7.3 Оюутны зөвлөл нь өөрийн тэмдэг, хэвлэмэл хуудас, билэгдэлтэй байна.

7.4 Тэмдгийг зөвхөн албан бичиг, тогтоол заавар, төлөвлөгөө, гэрээнд хэрэглэх бөгөөд санхүүгийн баримтанд хэрэглэхийг хориглоно.